

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202112188

1. Монголросцветмет” ТӨҮГ нь Бор-Өндөр -Зүүн цагаан дэл чиглэлийн 35 кВ-ын 45 км урттай ЦДАШ болон Зүүн цагаан дэл уурхайд 35/6/0.4 кВ-ын 2х1600 КВА хүчин чадалтай дэд станцын техникийн нөхцөл авч, зураг төсөл боловсруулж батлуулах зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Бор-Өндөр -Зүүн цагаан дэл чиглэлийн 35 кВ-ын 45 км урттай ЦДАШ болон Зүүн цагаан дэл уурхайд 35/6/0.4 кВ-ын 2х1600 КВА хүчин чадалтай дэд станцын техникийн нөхцөл авч, зураг төсөл боловсруулж батлуулах зөвлөх үйлчилгээ ба тус ажлыг хийж гүйцэтгэснээр ТӨҮГ-ын эзэмшлийн “Зүүн цагаан дэл” ордыг ашиглалтад оруулах, үйлдвэрийн бүтээмжийг өсгөх болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
 - Байгууллагын ерөнхий танилцуулга
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
 - Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар авч/ ирүүлнэ.
 - Тусгай зөвшөөрөл
 - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
 - Сүүлийн 2 жилийн аль нэг жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2021 оны 03 дугаар сарын 19–ны өдрийн 10 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2021 оны 03 дугаар сарын 22– ны өдрийн 10 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ

Хаяг: Улаанбаатар хот 51, ш/х – 002

Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө.

22-р хороо, “Монголросцветмет” ТӨҮГ-ын байр, 504 тоот,

И-мэйл: mailbox@monros.mn.

Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-458675, 976-11-450060-152